

Багшийн сурган хүмүүжүүлэх ур чадвар, ЭВ дүй

2014-2015 оны хичээлийн жил

Доктор, профессор Ц.Нацагдорж

“Маргад” дээд сургууль

“БАГШ” ГЭЖ ХЭН БЭ?

- Хүн нартад эхийн хэвлийгээс хүй тасран бодгал хүн болж нэгэнтээ төрдөг бол нийгмийн харилцаанд оролцон бие хүн болж хоёр дах удаагаа “төрдөг” бөгөөд энэ төрөлтийн эх нь багш хүн юм.
- Ийм ч учраас багшийн ажлыг “Нартад эгнэшгүй нандин сайхан алба” хэмээн Чехийн нэрт сурган хүмүүжүүлэгч Я.А.Коменский тодорхойлсон байдаг.
- Багшаар амьдралынхаа анхны замын жолоог татуулж хадуурвал зэмлүүлж, хааяа бас магтуулж явсанаа хүн болгон дурсан ярих дуртай байдаг. Ер нь хүний учиртай, утгатай амьдралын хувь тавиланд багш хүний хийж, бүтээж, үлдээсэн үнэт зүйлс хэмжээлшгүй.



“БАГШ” ГЭЖ ХЭН БЭ?

- Багш гэж хэн бэ? Монголын ард түмэн эрт дээр үеэс эрдэм мэдлэгтэй хүнийг “багш” хэмээн дээдлэн хүндэлж, багшийг дээдийн гурван эрдэнийн нэгд оруулсан байдаг билээ.
- Олон улсын “Багшийн харти” хэмээх баримт бичигт : “Багшид сургуулийн хүрээнд сурагчдыг сургах, хүмүүжүүлэх ажлыг гардан хийж байгаа бүх хүмүүсийг багтаана”¹ гэж тэмдэглэжээ.
- Энэхүү харти нь багш нарын эрх, нийгэм эдийн засгийн болон мэргэжлийн байр суурь, нийгэмд гүйцэтгэх үүргийг зарлан тунхагласан олон улсын чухал баримт бичиг билээ.
- Улс бүхэн энэ баримт бичгийн бүхий л заалтыг хэрхэн биелүүлж байгаа талаар ЮНЕСКО-д бичгээр мэдээлж байх үүрэг хүлээсэн байдаг байна. Эл харти нь өнөөдөр багшийн статуст хамрагдах бүхий л асуудлын дэлхийн стандарт болж байна.



“БАГШ” ГЭЖ ХЭН БЭ?

- Монгол Улсын Боловсролын хуулинд тодорхойлсноор, багш нь төрийн боловсролын үйлчилгээг олон түмэнд хүргэгч төрийн үйлчилгээний албан хаагч юм.
- Энэ бүгдээс үзвэл : Багш хэмээх нь өсвөр залуу үеийнхэнд амьдрал ахуйд нь хэрэгтэй мэдлэг, арга барил, чадвар, туршлага олж авахад нь туслах, тэднийг иргэн бие хүн болон хөгжин төлөвших, нийгэмших ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион явуулах ур чадвар бүхий бие хүн юм.



БАГШИЙН МӨН ЧАНАР

- *Хүүхдэд хайртай, тэднийг бидний ирээдүй хойч үе гэж хүндэтгэдэг байх*

Хүүхдэд хайртай, тэдэнтэй ажиллах дур сэтгэл ихтэй бол амжилт гаргах нэг үндэс болно. Хүүхдийг ихэд хүндэтгэдэг, тэдэнд үнэн санаанаасаа тусалдаг, ойр дотно элэгсэг зөв харьцаатай байх нь багш хүний гол шинж мөн. Бас энэ ажилдаа дуртай, шударга зарчимч шаардлагатай байх хэрэгтэй.

- *Иргэний ухамсар, хариуцлагатай байх*

Хэний ч хяналт, шахалтгүйгээр багшлах ажлаа чин сэтгэлээсээ хариуцлагатай, бүтээлч санаачлагатай гүйцэтгэдэг. Ямар ч нөхцөл байдалд асуудал шийдвэрлэхдээ хувийн, өнөөдрийн ашиг сонирхлоо урьтал болгохгүй байх зан чанар шингэсэн байх нь чухал.

- *Гоо сайхны мэдрэмжтэй байх*

Багшийн үйл хөдлөл, хэл яриа нь зөв зохистой, оновчтой, сайхан байхын зэрэгцээ шавийнхаа болон нөхдийнхөө үйл ажиллагаа, байгаль, нийгмийн орчны сайхныг олж харж, түүнээс суралцдаг байх нь сайн багшийн нэг чухал чанар юм.



БАГШИЙН МӨН ЧАНАР

- *Сурган хүмүүжүүлэх ажилд дур сонирхолтой байх*

Багш нь хүүхдэд хайртай байхын зэрэгцээ, өөдрөг үзэлтэй, өөрийнхөө ажил, мэргэжлийн нийгмийн ач холбогдлыг ухамсарлан ойлгосон цагт сурган хүмүүжүүлэх ажилдаа дур сонирхолтой болох үндэс тавигдана.

- Багшийн сурган хүмүүжүүлэх ажилдаа дур сонирхолтой болоход түүний хамт ажилладаг нөхөд, хамт олон, удирдлагын төлөвшил чухал нөлөөтэй. Эвсэг, өөдрөг үзэлтэй, ажил хэрэгч, шинийг эрэн хайгч хамт олон, удирдах ажилтан багшийн урам зоригтой ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

- *Нийтэч, хамтач байх*

Багш нь хүнтэй, хүүхэдтэй ажилладаг хүн учраас бусадтай илэн далангүй, ил тод харьцаж, өөрийгөө илэрхийлж, бусдыг ойлгож, өөрийнхөө болон бусдынхаа хэрэгцээ сонирхлыг хангахын тулд хамтран ажиллах чадвартай байх шаардлагатай.

- *Шударга, бусдад болон өөртөө шүүмжлэлтэй ханддаг байх*

Багш нь аливаа асуудалд түүний дотор өөрийнхөө болон бусдын үйл ажиллагаанд хүүхдийн эрх ашгийн үүднээс бодитой хандаж, тэдний хүмүүжил төлөвшилд сөрөг нөлөөтэй үзэгдэл, үйл хөдлөлийг засах, гаргахгүй байхын төлөө ажилладаг байх шаардлагатай.

- Сурган хүмүүжүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэстэй явуулахыг чухалчилж, үйл ажиллагаагаа энэ талаас нь үнэлж дүгнэдэг байвал үр дүнд хүрнэ.



БАГШИЙН МӨН ЧАНАР

- *Ажилсаг, бусдад үлгэр дууриалтай байх*

Багш нь өөрийн бүхий л зан, үйл хөдлөлөөрөө зөвхөн шавь нартаа төдийгүй, тэдний эцэг эх, ах, эгч, олон түмэнд үлгэр болж байдаг. Гэхдээ зориуд зохиомол хиймэл зан үйл огт зохисгүй. Иймд багш нь бие хүн, иргэний хувьд тодорхой хэмжээнд төлөвшсөн байж өөрийгөө зөв зохистой авч явах чадвартай болсон байх шаардлагатай. Багш хүн бүхнийг мэдэгч байх албагүй. Харин ажилсаг, байнга суралцаж, өөрийгөө өөрчлөн хөгжүүлж байдаг хүн байх нь чухал.

- *Шинэлэг сэтгэлгээтэй, өдрөг үзэлтэй байх*

Багш нь өдрөөс өдөрт өсөн торниж, хөгжиж байгаа хүүхэдтэй ажиллахын зэрэгцээ, жилээс жилд хөгжин өөрчлөгдөж буй нийгмийн ирээдүйг бэлтгэж байгаа хүн тул ирээдүйн сайн сайханд итгэж, шинэ зүйлийг мэдэрч өөрийнхөө сэтгэлгээ, ажлын арга барилыг байнга өөрчлөн шинэчлэхийг хичээдэг, түүнийг өөрийнхөө үүрэг гэж ойлгосон байх шаардлагатай.

- *Өөрийгөө болон бусдыг хүндэлдэг, өөртөө болон бусдад итгэдэг байх*

Багш нь шавь нартаа итгэж, тэдний итгэл найдварыг хүлээнээр сая сайн багш болж чадна. Түүнчлэн хамт ажилладаг нөхөд, эцэг эхчүүдийг хүндэтгэж, тэдэнд итгэж байж тэдний итгэл, хүндэтгэлийг өөртөө татаж чадна.



БАГШИЙН МӨН ЧАНАР

- *Өөрийн гэсэн сурган хүмүүжүүлэх үзэл бодол, зарчимтай байх*

Багш нь хувь мэргэжилтний хувьд өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй, сурган хүмүүжүүлэх үзэл бодолтой, үйл ажиллагаандаа баримталдаг зарчимтай байх шаардлагатай. Жинхэнэ сайн багш нь шавьдаа өвлүүлэн үлдээсэн тодорхой зүйлтэй, түүгээрээ өөрөө ч бахархдаг, шавь нь ч хүндэлдэг байх учиртай.

- *Мэргэжлийнхээ нэр хүндийг эрхэмлэдэг байх*

“Багш” мэргэжил нь хувь хүний төдийгүй, өрх гэрийн удам угсаа, бүс нутаг, улс орны ирээдүйн төлөө ажиллахыг шаарддаг мэргэжил тул хувь багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа энэ хүндтэй мэргэжлийн нэр хүндийг илэрхийлж байдаг. Үүгээрээ багшийн нэр төрийг ч хамгаална.

- Манай монголчууд:

“Ноён ноён гэмээ нь

Нутаг зуураа ямбатай

Номтой эрдмийн багш

Газар бүхэнд хүндтэй” хэмээн багшийн нэр хүндийг өндрөөр үнэлж ирсэн сайхан уламжлалтай билээ.



БАГШИЙН ЁС ЗҮЙН УЛАМЖЛАЛ

БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ОНЦЛОГ

- *Багшийн үйл ажиллагааны объект нь өсч хөгжиж байгаа хүүхэд залуусын хөгжин төлөвших үйл явц, сурч танин мэдэх үйл ажиллагаа байдаг.*

Сурагчид нь чухам ямар хүн болж төлөвшсөнөөр багшийн хөдөлмөр үнэлэгддэг. Хүүхэд өсч том болсон хойноо суралцаж байсан сургуулийнхаа барилга байшин, ширээ сандал, самбар зэргийг санахаасаа илүүтэй сургаж хүмүүжүүлж байсан багш нараа л урьдаар дурсан санах нь их байдаг.

- *Ямар ч багш өнөөдрийг харж ажилладаггүй, ирээдүйг харж оюуны “үйлдвэрлэл” явуулдаг.*

Багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны зорилго нь “идеал” шинжтэй байдаг. Энэхүү сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны зорилгыг хэрэгжүүлэх сургалтын орчин нөхцөл, агуулга, арга зүй нь багшаас шалтгаалахын зэрэгцээ, бусад хүчин зүйлээс, нийгэм эдийн засгийн олон хүчин зүйлээс давхар шалтгаалдаг.

- *Өөрийгөө байнга хөгжүүлж, боловсруулж байхыг шаарддаг*

Өнөөдөр мэдлэгийн зуунд амьдарч байгаа хэн бүхэн насан туршдаа суралцах шаардлагатай болж байна. Тэр тусмаа багш хүн бол мөнхийн сурагч юм. Тэгэхдээ өөрөө суралцаад зогсохгүй, бас хүүхдийг суралцаж чаддаг болоход нь туслах ёстой. Үүний тул өөрийн мэргэжил, заадаг хичээлдээ дур сонирхолтой байж, заах хичээлээ амьд сонирхолтой болохуцаар бэлтгэж байх хэрэгтэй. Хоолыг амт сайтай хийвэл идэх дур өсдөгийн адил чамбай сайн бэлтгэсэн хичээлд сурагчид дуртайяа оролцож, хамтран ажилладаг билээ.



БАГШИЙН ЁС ЗҮЙН УЛАМЖЛАЛ

БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ОНЦЛОГ

- *Багшийн мэргэжил нь бүтээлч сэтгэлгээ шаарддаг онцлогтой*

Багш хүн сурган хүмүүжүүлэх үзэгдлийг урьдчилан төсөөлөх, түүнийг ургуулан бодох, үйл ажиллагааны олон хувилбар боловсруулах, үр дүнг нь урьдчилан тооцоолох шаардлагатай байдаг. Багшийн өдөр тутмын үйл ажиллагаанд урьдаас тооцоолж мэдэхийн аргагүй гэнэтийн зөрчил, янз бүрийн бэрхшээл, асуудал гардаг. Энэ үед оновчтой шийдлийг хурдан хугацаанд гаргах чадвартай байх шаардлагатай.

- *Зохион байгуулах ур чадвар, уян хатан арга барил шаарддаг*

Хүүхэд /хүн / бүр адилгүй, янз бүрийн орчинд төрж өссөн соёлын өвөрмөц төлөвшилтэй байдаг тул тэр бүхэнд таарсан арга барил, зорилго, зорилттой ажиллах шаардлага багш хүнд ямагт бий болж байдаг.

Багш хүн олон янзын зан авиртай хүүхдүүдтэй ажилладаг учир өөрийгөө байнга эзэмдэх, хэлж буй үг, хийж буй зан үйлээ сайтар хянах, аливаад хүлээцтэй, тэвчээртэй хандах шаардлагатай байдаг.

- *Ажлын үр бүтээл нь ямагт хамтын шинжтэй, эцсийн үр дүн нь урт хугацааны дараа харагддаг*

Ийм учраас багш хүн сурагчид, тэдний эцэг эх, бусад багш нартай хамтран ажилладаг, мэдээлэл, туршлагыг хуваалцдаг, мэдлэгийг хамтран бүтээдэг байх хэрэгтэй. Учир нь үйл ажиллагааных нь үр нөлөө нэг хүн төдийгүй гэр бүл, улс орны ирээдүйтэй холбогддог.

- *Я.А.Коменский “Багшийн мэргэжил бол бүх урлаг дотроос хамгийн хэцүү нь мөн” гэж хэлсэн байдаг.*



БАГШИЙН ЁС ЗҮЙН УЛАМЖЛАЛ

БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ОНЦЛОГ

- *Багшийн ажил нь олон хүүхдийг нэгэн зэрэг хамарч, тэдний нүдэн дээр ил явагддаг учир байнга бусдын хараа, хяналт дор хэрэгждэг онцлогтой.*

Байнга зөв үлгэр дууриал үзүүлж байх нь энэ мэргэжлийн бас нэг онцлог юм. Иймд багшийн хувийн үлгэр жишээ нь ямар ч сурах бичиг, ном зохиол, яриа ухуулга, сайшаал, шийтгэлээс хол давуу бөгөөд юугаар ч зүйрлэшгүй хүч , нөлөө юм.



БАГШИД ТАВИХ ШААРДЛАГА

- Үе үеийн нийгэм, багшид өөр өөрийн шаардлагыг тавьсаар ирсэн билээ. Өнөөгийн ажлын байр болон нийгмийн хэрэгцээ шаардлага нь урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр хурдан өөрчлөгдөж, улам өндөр шаардлага тавих болжээ.
- Тэдэнд алхам тутамд үүсэн бий болж байгаа шинэ асуудлыг аль болох оновчтой, бүтээлчээр шийдвэрлэж чаддаг иргэн-мэргэжилтэн хэрэгтэй болж байна.
- Учир нь хувь суралцагчаас хурдацтай өөрчлөгдөн хувьсч байгаа нийгэмд янз бүрийн мэдээллийн эх үүсвэрийг ашиглан, асуудлыг олон талаас нь авч үзэх замаар шинэ мэдлэгийг бүтээж сурахыг шаардаж байна.



БАГШИД ТАВИХ ШААРДЛАГА

- Даяаршлын зууны иргэн-мэргэжилтэн асуудлыг зөвхөн хамт ажилладаг нөхөдтэйгөө төдийгүй орон нутгийн хийгээд дэлхийн олон нийт, тэдний төлөөлөл болсон байгууллага, хувь хүмүүстэй харилцаж, хамтран ажиллах замаар шийдвэрлэх, аливаа асуудлыг бодит амьдрал дээрх олон ургальч үзэл, хандлагын үүднээс авч үзэж чаддаг байх хэрэгтэй болжээ.
- Иймд орчин үеийн багшаас бусадтай хамтран ажиллах, ажил хэрэгч харилцаа тогтоох чадвартай байхыг шаардаж байна.
- Ажлын байрны дээрх шинэ шаардлага нь багшид мэдээлэл дамжуулагчийн үүрэг, монологи ярианы хэлбэрээс салж, мэдээлэл, туршлагыг хуваалцсан байр сууринд шилжих, өөрийгөө суралцагч, мэдлэгийг хамтран бүтээгч гэж үзэхийг шаардаж байна.



БАГШИД ТАВИХ ШААРДЛАГА

- Орчин үеийн нийгмээс багшид тавьж буй нэг гол шаардлага бол хувь суралцагч өөрийгөө үнэлэх, хувийн хариуцлагаа ухамсарлахад нь туслаад зогсохгүй, хүүхэд залуучуудад өөрчлөлтийг олж харж чаддаг болоход нь, түүнд өөрийгөө зохицуулан амьдарч сурахад нь, насан туршдаа үргэлжлүүлэн суралцахад нь туслах хэрэгтэй болж байна.
- Иймд орчин үеийн багш хүн шинийг эрж хайх, шинийг хүлээн авах, хэрэгжүүлэх чадвартай, байнгын бүтээлч хандлагатай байх хэрэгтэй юм.
- Шинжлэх ухааны системтэй мэдлэг, итгэл үнэмшил, сурган хүмүүжүүлэх ажлын тодорхой хэмжээний ур чадварын бэлтгэл, хүнийг таньж мэдрэх мэдрэмж, харилцааны эв дүйтэй байх нь дээрх шаардлагыг хэрэгжүүлэх үндэс суурь нь болно.



БАГШИД ТАВИХ ШААРДЛАГА

- Багш нь янз бүрийн нөхцөлд олон янзын хүүхэдтэй ажиллах учраас байнгын санамсаргүй болон зүй тогтолт зөрчил бэрхшээлтэй тулгарч байдаг.
- Эдгээр зөрчил бэрхшээлийг даван туулах арга замыг хайх нь багшаас бүтээлчээр ажиллахыг, сурган хүмүүжүүлэх судалгааны ажил хийхийг шаарддаг.
- Багш сурагчдаа, сургалтын баримт бичиг, хэрэглэгдэхүүнийг судалж байж ажлаа төлөвлөдөг. Ийнхүү багш судлаач байх шаардлага улам өсөн нэмэгдэж байна.



БАГШИЙН ЁС ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

- Багш хүн дээдсийн болон ахмад үеийн сурган хүмүүжүүлэх арга барилыг гарамгай өвлөн авч цаг үеийнхэ туршлага дээр шинэлгээр хэрэгжүүлдэг, ухуулан хүмүүжүүлэх, сургах, хайрлах, итгүүлэх, авьяастай, уран илтгэгч, цуцалтгүй хөдөлмөрлөгч байх ёстой.
- Өөрийгөө байнга судлах, “өөр болъё” гэсэн оролдлого өөртөө тавих, бусад хүмүүстэй өөрийгөө харьцуулах,
- Биеэрээ үлгэрлэдэг, сурган хүмүүжүүлэх, сонгодог уламжлалаас суралцдаг, эрдэм мэдлэгээ байнга дээшлүүлдэг, хөөрч дэвэрч зоригжуулж, хөлс чийхартал зэмлэдэг, сэнхрүүлэх авьяастай байна.
- Улс орныхоо гадаад амьдрал, сурган хүмүүжүүлэх аргыг судалсан, олон газар явж нүд тайлсан зэрэг бүх үйлсээрээ хошуучлагч байж хойч үеийнхэндээ бахархах гавьяа байгуулдаг, биеэ авч явах чадвартай, ухаарал хайрлал, өрөвдөх сэтгэлийг эзэмшсэн, нинжин сэтгэлтэй байвалл зохино.



БАГШИЙН ЁС ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

- Сурган хүмүүжүүлэгч хүн ёс суртахууны хувьд өөрийн үүрэг хариуцлагаа ойлгосон байх ёстой. Энэ нь өсвөр үеийнхнийг чанартай, үр дүнтэй хүмүүжүүлэх гэсэн сайн дурын хүслээр нь илэрнэ.
- Багш нийгмийн амьдралд өөрийн хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа түүнийхээ ач холбогдлыг ухааран ойлгодог, шударга байх ёстой.
- Багш хүн , мэргэжил нэгт нөхөд, сурагчдын өмнө нэр хүндтэй, “нинжин сэтгэлтэй” ёс суртахууны хариуцлагатай байх ёстой.
- Сурган хүмүүжүүлэх эв дүйтэй байх. Энэ нь хүүхдүүдтэй зөөлөн сэтгэлийнхээ угаас зөөлөн харьцдаг, сурагчдын сэтгэлийг бүрэн эзэмшдэг , шударга шаардлагатай ханддаг байхыг багшийн эв дүй гэнэ.



БАГШИЙН ЁС ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

- Багш, суралцагч харилцан бие биеэ ойлгодог, хүндэлж итгэдэг, эвсэг нөхөрсөг, санаа бодлоо чин сэтгэлээсээ ярьдаг, өөрийгөө шүүмжлэхэд дургүйцдэггүй байх ёстой.
- Багш хүнд хатуу ширүүн, өр хатуутай, бүрхэг дуугүй, яншаа уймраа, сэжигч, үглээ, залхуу заншил эрс цээртэй.
- Цэцэн мэргэн хэллэгтэй, сэтгэлийн соёлтой, зөн бэлгэтэй, байгальтай зөв харьцдаг байх хэрэгтэй.



БАГШИЙН ЁС ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

- Багш суралцагчдаа бүтээлчээр , бие даан суралцах чадвар эзэмшүүлэхэд байнга анхаарна
- Суралцагчдаа тэдний сурахын төлөө чөлөөтэй эрэл хайгуул , идэвх санаачлага гаргахад дэмжлэг үзүүлж, туслан зөвлөх, жолоодох , урмыг нь тэтгэн дэмжинэ
- Багш хичээлээ мэргэжлийн түвшинд бэлтгэж, суралцагчдынхаа сонирхол идэвхийг нь хөгжүүлэхүйц хэмжээнд зохион байгуулна.
- Багш нь мэдлэг боловсрол, заах арга ур чадвар, судалгаа шинжилгээ хийх чадвараа байнга хөгжүүлэн сайжруулна.



БАГШИЙН ЁС ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

- Судалгаа шинжилгээний ажил хийх чадвараа байнга хөгжүүлэн сайжруулахын төлөө өөрийн бүхий л хүч чадлаа дайчлана.
- Чадвар, хүчин, чармайлтыг бодотой , шударга үнэлдэг байна.
- Багш суралцагчийн харилцаанд итгэл, хүндэтгэлийг эрхэмлэж өөрийн биеэр үлгэрлэн манлайлана.
- Багш суралцагчидтай хүндэтгэлтэй харилцаж, ажил төрлийн холбоотой бодотой санал , шүүмжлэлийг хүлээн авч, аливаа маргаан зөрчлийг эв дүйгээр шийднэ
- Багш хувийн үлгэр дууриал сайтай, харилцааны соёлтой байна.



ХАРИЛЦААНЫ ТУХАЙ

- Хамтын үйл ажиллагааны эрэлт хэрэгцээнээс урган гарч байгаа, хүмүүсийн хооронд хэлхээ холбоо тонтоож, түүнийгээ цаашид хөгжүүлэхэд чиглэсэн олон талт үйл явцыг **ХАРИЛЦАА** гэнэ
- Харилцаа нь олон төрлийн үүрэг гүйцэтгэдэг. Үүнд:
- Нэгтгэх холбох-Хамтын үйл ажиллагааны явцад хүмүүсийг холбож нэгтгэж өгдөг
- Төлөвшүүлэх-Багш, эцэг эхийн 2 талын тдэвхтэй харилцаа нь хүүхдийг төлөвшүүлэхэд яухал үүрэгтэй
- Солилцох-Багш-суралцагчдад сурах арга барил эзэмшүүлэхэд харилцаа чухал үүрэгтэй
- Илэрхийлэх, батлах-Суралцагчид бусдадаа өөрийгөө ойлгуулахрийн авьяас чадварыг батлан харуулах боломжийг нээж, нөөц чадвараа хөгжүүлэхэд тус дэм болдог
- Зохион байгуулах, хадгалах- Багш-суралцагчдын хооронд эерэг сэтгэгдэл төлөвшүүлэхэд нөлөөлдөг
- Дотоод харилцаа-Өөртөө хүүрнэн өгүүлэх, өөрийн “дотор хүн”-тэй харилцах үүргийн нэг юм.
- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад эдгээр харилцааны үүргүүд цогц хэлбэрээр илэрч байдаг.



БАГШ-СУРАЛЦАГЧИЙН ХАРИЛЦАА

- Харилцааны асуудлыг судлах явцад сургуулийн практикт багш сурагчдын хооронд дөрвөн төрлийн харилцаа байдгийг судлаачид нэгэнтээ тогтоожээ. Үүнд:
- **Тогтвортой эерэг харилцаа:** Ийм харилцааны онцлог бол багш бүх хүүхдэд өөдрөг ханддаг, сэтгэл зүйн эерэг уур амьсгал бүрдүүлж чаддаг, багш цаг ямагт найрсаг, амгалан тайван, хүлээцтэй байж чаддаг. Ийм багшийн сурагчид ядрахгүйгээр амжилттай сурч хөгждөг.
- **Идэвхгүй эерэг харилцаа:** Ийм харилцааны онцлог бол багш уур уцааргүй дэндүү амгалан тайван ба түүний энэ байдал сурагчидтай харилцах харилцааг идэвхгүй болоход нөлөөлдөг. Ийм багшийн сурагчид идэвхтэй биш боловч сурлага хүмүүжлээр гайгүй сайн байдаг байна.
- **Тогтворгүй харилцаа:** Ийм харилцааны онцлог бол багш сэтгэл санааны эерэг байдалд байснаа тун удалгүй сөрөг байдалд орж туйлбаргүй авирладаг. Энэ нь сурагчдын сурлага, хүмүүжилд тийм ч сайнаар нөлөөлдөггүй. Ийм тогтворгүй байдлыг “хаврын тэнгэр шиг” гэж нэрлэх нь бий. Багш нар ийм байдлаас аль болох зайлсхийх ёстой юм. Учир нь багш ийм зан авир гаргахад сурагчид айдаст автаж тэдний сурах эрч хүч, идэвх заавал буурдаг байна.
- **Сөрөг харилцаа:** Ийм харилцааны онцлог бол тодорхой нөхцөлд багш өөрийгөө хянах, эзэмдэх чадвараа алддаг явдал юм. Ийм багш байнга уурлаж уцаарлах, загнах, үглэх, сурагчдад уураа гаргах, тэднээс байнга өө эрэх, үргэлж сэтгэл хангалуун бус байх зэрэг онцлогтой. Энэ байдал нь хүүхдэд багшаасаа маш их айх байдлыг бий болгодог. Мөн сурагчид далд ухамсрын түвшинд багшийн энэ сөрөг зан байдлыг хүлээн авч хожмын өдөр уурлах гэх мэт сөрөг зан чанарыг сэмээрхэн даган дууриах төлөвшил олгодог аюултай зүйл юм.
- Сөрөг харилцаа нь багш болон сурагчдад бие биеэ ойлгоход хэзээ ч тус нэмэр болдоггүй ба үргэлж шинэ зөрчлүүдийг үүсгэж байдаг учир багш ийм байдлаас ухамсартайгаар зайлсхийж чаддаг байх ёстой.



БАГШ-СУРАЛЦАГЧИЙН ХАРИЛЦАА

- Багш харилцааны алдаа гаргахгүй байхыг хичээхийн хамт харилцааныхаа ур чадварыг байнга хөгжүүлэн сайжруулахын төлөө чармайх хэрэгтэй. Үүний тулд:
- Ямар ч хүүхэдтэй хэзээ ч “дээрээс доош” харсан хандлагаар бүү харилц, бие биеэ хүндэлсэн, найрсаг, нээлттэй харилцааг эрхэмлэ
- Сурагчидтайгаа байнга мэндэлж бай
- Хүүхдийг үргэлж анхааралтай сонсч ойлгохыг хичээ
- Өөрийнхөө санаа бодлыг сурагчдад тулгахгүй байхын хамт өөрийгөө бусдад ойлгуулж сур
- Харилцаанд үл ойлголцох асуудал гарч болохыг бүү март. Үг бүрээ бодож хэлэхийг хичээ
- Ямар ч насны хүүхэд дотроо “багш надад ямар ханддаг бол?” гэдгийг үргэлж бодож мэдэхийг хүсч байдгийг бүү март. Иймээс боломж л олдвол та түүнд сайн ханддаг, түүнийг хүлээн зөвшөөрдөг, ойлгохыг хичээдэг, туслахад бэлэн гэдгээ мэдрүүлж бай
- Хүүхдийг хий хоосон шүүмжлэх, хэт магтах юм уу муулах, үглэх, муу үгээр хэлэх, ялгаварлах зэргээс цаг ямагт зайлсхийж бай
- Хүүхдийн сурах чадвар, сонирхол, үзэл санаа, авьяас билигт өөдрөг хандаж хэвш
- Хүүхэд үргэлж нэг хэвээр байдаггүй, тэр байнга өсөн хөгжиж байдаг тул багш та харилцаа хандлагаа мөн үргэлж боловсронгуй болгож байгаарай



БАГШ-СУРАЛЦАГЧИЙН ХАРИЛЦАА

- Багш хичээл дээр суралцагчидтай хамтын үйл ажиллагаа явуулж, харилцах явцад Харилцааны хандлагын хэд хэдэн хэв маяг буюу зан төлвийн загварыг бий болгодог.Тэдгээрийг ерөнхийд нь дараах хэлбэрт хувааж болно.
- Дарангуйлах загвар- /Монблан загвар/:- багш суралцагчдад хөндий хүйтэн ханддаг. Ийм байдалд суралцагчид идэвхгүй сонсогчид болно. Тэдний хооронд ямар ч холбоо харилцаа үүсдэггүй. Сурган хүмүүжүүлэх үүрэг зөвхөн мэдээлэл өгөхөд чиглэгддэг.
- Үр дагавар нь—сэтгэлзүйн холбоо харилцаа тогтоогүй учир суралцагчид идэвх, санаачлагагүй байдалд ордог.



БАГШ-СУРАЛЦАГЧИЙН ХАРИЛЦАА

- **Харилцаа холбоо тогтоодоггүй загвар**-/Цагаан хэрэм/-Сэтгэл зүйн агуулгаараа эхний загвартай ижил төстэй.Харин түүний онцлог нь багш суралцагчдын хооронд гэнэтийн , санамсаргүй болон зориудын саад бэрхшээл үүсдэг ч тэдний хооронд ямар нэгэн хэмжээгээр буцах холбоо бий болдог.
- Ийм саад бэрхшээлээс дурдвал багш оюутны аль нэг нь нөгөөтэйгээ хамтран ажиллах хүсэл сонирхолгүй байх, хичээл хэлэлцүүлгийн шинж чанартай бус зөвхөн мэдээлэл төдий болох , багш өөрийн байр сууриа хяналт болгоомжгүй , дөвийлгөн хэлэх, оюутанд өршөөнгүй хүлцэнгүй хандах зэрэг юм.
- **Үр дагавар нь:**Багш- оюутны хоорондын харилцаа идэвхгүй сул, оюутны багшид хандах хандлага төдийлөн сайн биш.



БАГШ-СУРАЛЦАГЧИЙН ХАРИЛЦАА

- Хувийн сэтгэл зүйн онцлогийг үзэж хандах загвар
\\Локатор загвар\\-багш оюутныг шилэн сонгож ханддаг.Тэрээр ангийн бүх оюутнаар баримжаа авдаггүй, зөвхөн зарим нэгүүдэд нь тухайлан арай илүүханддаг, авьяас билигтэй , тэргүүний манлайлагч юмуу эсвэл сул идэвхгүй оюутныг илүү анхааран үздэг.
- Харилцааны явцад багш тэдэн дээр тулгуурлаж анги хамт олны санаа сэтгэлд нөлөөлөхийг урьдал болгодог, анхаарлаа голчлон тэдэнд хандуулдаг.Харилцааны энэ загварын шалтгаан нь оюутанд нэг бүрчлэн хандах арга барилыг нийт суралцагсадтай хамтран ажиллах хэлбэртэй хослуулж чаддаггүйтэй холбоотой.
- Үр дагавар нь:Багш- оюутны хамт олны харилцаанд нэгдмэл үйл ажиллагаа алдагддаг.хүмүүсийн хоорондын харилцаа тухайн үеийн нөхцөлөөс шалтгаалах буюу өнгөц байдалд явагддаг.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УР ЧАДВАР ГЭЖ ЮУ ВЭ?

- Энэ бол тухайн багшийн сурган хүмүүжүүлэх авьяас, ёс зүй, эв дүйн нэгдэл юм. Сурган хүмүүжүүлэх авьяас чадвар хэмээх нь танин мэдүүлэх, сургах, зохион байгуулах, хүүхдийг шинжин таних өндөр чадвар, харилцааны соёл эзэмшилтийг хэлнэ.

Багшийн сурган хүмүүжүүлэх ёс зүй хэмээх нь:

- Ажилдаа бүтээлчээр хандаж хүүхдийг хайрлаж хөгжүүлэхийг хичээдэг
- Хүүхдийн дотоод сэтгэлийг мэдэрдэг
- Эцэг эхэд хүндэтгэлтэй хандаж тэдэнтэй хамтран ажилладаг
- Хүүхэд бүрт анхаарал халамж тавьж тэдний нэр хүндийг хамгаалдаг
- Хамт олныхоо ажил үйлд хувь нэмрээ оруулж уламжлалыг хүндэтгэдэг
- Ёс суртахууны хувьд үлгэр жишээч байхыг хэлнэ
- Багшийн сурган хүмүүжүүлэх эв дүй хэмээх нь:
- Хүүхдийн үгийг тэвчээртэй сонсч тэдэнтэй эелдэг зөөлөн харилцдаг байх
- Хүүхдийг бүрэн ойлгож тэднийг өөртөө татаж чаддаг байх
- Сэтгэлийн хөдлөлийн мөчид өөрийн биеэ барьж чаддаг байх
- Хошин үг үг хэллэгээр хүүхдийг ухааруулж чаддаг байх
- Хэнтэй ч хэрүүл маргаан үүсгэдэггүй, хэл ярианы өндөр соёлтой байхыг хэлнэ.

Сурган хүмүүжүүлэх эв дүй бол багшийн мэргэжлийн өвөрмөц онцлог шинж юм. Энэ нь тухайн багшийн үг яриа, дадал хэвшил, харилцаа хандлага, үзэл бодлоор илэрдэг.

Сурган хүмүүжүүлэх эв дүйгүй бол тухайн хүнтэй ажиллаж сургана гэдэг бүтэшгүй зүйл юм. Сурган хүмүүжүүлэх эв дүй нь багшийн ур чадварыг бүрдүүлж байгаа олон чухал шинжийн нэг юм.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭВ ДҮЙ ГЭЖ ЮУ ВЭ?

- Сурган хүүмүүжүүлэх эв дүй юугаар илрэх вэ гэвэл тодорхой нөхцөлд хүнийг хүн болгох арга, хэрэглүүрийг олж онож овсгоотой хэрэглэх мэргэжлийн онцлог чадварыг хэлдэг байна. Сурган хүмүүжүүлэх онол практикт эв дүйг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:
- Сурган хүмүүжүүлэх эв дүй нь багш сурагчтай харилцах харилцаанд илрэх зан үйлийн хэм хэмжээг баримтлахыг хэлнэ.
- Сурган хүмүүжүүлэх эв дүй нь тухайн багшийн хувийн сэтгэл зүйн чанарын онцлог юм. Багшийн ажлын нэг онцлог, багшийн сурган хүмүүжүүлэх ур чадварын нэг чухал шинж юм.
- Сурган хүмүүжүүлэх эв дүй нь багш сурагчийн хооронд бий болдог зөрчилдөөн гарахаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсэргүүцэл, дургүйцлийг зөөлрүүлж тайвшруулах, аятай сэтгэгдэл төрүүлэхэд оршино.
- Хэрвээ багш хүн шавь нартаа итгэгдье, тэдний анхаарал, санаа сэтгэлийг татъя, өөрийн санаа бодол хүсэл зорилгодоо оруулья, ойлголцъё гэвэл дараах хэдэн зүйлийг баримталж ажиллах ёстой. Үүнд:
- Эв дүйтэй харилцаа хандлагын янз бүрийн арга , хэрэглүүрийг чадварлаг ашигладаг хэрэглэдэг байх
- Хүүхдийн дургүйцэл, эсэргүүцэл, сөрөг хандлагын цаад учир, сэдлийг олж харж чаддаг байх
- Хүүхэд нэг бүрийн дотоод сэтгэлийг ойлгож, зөв үнэлж дүгнэж чаддаг байх
- Үг яриа, үйл хандлага, нөлөөлөл, шаардлагад хүүхэд ямар хариу үйлдэл/баярлах, дэмжих, хүлцэн хүлээн авах, эсэргүүцэх, дургүйцэх гэх мэт/ үзүүлэхийг урьдчилан харж мэддэг байх



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УР ЧАДВАР ГЭЖ ЮУ ВЭ?

- Сурган хүмүүжүүлэх ухааны бүтээлүүдэд сурган хүмүүжүүлэх ур чадварыг олон янзаар ангилсан байна. Үүнд:

- *Зохион байгуулах ур чадвар*

Энэхүү ур чадвар нь бүх сурагчид хичээлийн явцад юу юу хийх, яаж хийх, ямар цаг хугацаа зарцуулах зэргийг тухайн нөхцөлд зохицуулан оновчтой нарийн төлөвлөхийн хамт эдгээрийг сурагчдаар хийлгэхийн тулд багш өөрөө юу юу хийх, юу бэлтгэх зэргийг давхар төлөвлөх үйлүүдийг өөртөө багтаадаг нарийн нийлмэл яадвар юм. Жишээ нь, сурагчдын унших материалыг бэлтгэх, тэдэнд тавих асуултаа бэлтгэж боловсруулах, тэднээр бие даалгаж хийлгэх дасгалуудыг бэлтгэх, сурагч дэвтэртээ юу юу бичиж тэмдэглэсэн байх гэх мэтийг урдаас бэлтгэж төлөвлөхдөө тэдний нас, сурах чадвар, онцлог, сонирхол зэрэг олон зүйлийг харгалзан үзнэ. Энэ бүхнийг үндэслэж багш өөрийн сурган хүмүүжүүлэх үйл, үйлдлүүдийг бэлтгэж төлөвлөнө.

Үүнээс үндэслэн:

Зохион байгуулах ур чадвар

- а/ сурагчдын сурч танин мэдэх үйлүүдийг төлөвлөн зохион байгуулах гэсэн хоёр төрлийн үйл, үйлдлүүдийг багтаадгаараа онцлог юм.

- б/ багш өөрийнхөө сурган хүмүүжүүлэх үйлүүдийг бэлтгэж төлөвлөх



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УР ЧАДВАР ГЭЖ ЮУ ВЭ?

- Харилцааны үр чадвар

Харилцааны үр чадвар нь багшийн сурагчидтай харилцаа тогтоох, түүнийгээ үргэлж эерэг байлгах онцгой чадвар юм.

- Багшийн сурган хүмүүжүүлэх харилцаа нь сурагч бүрт цаг үргэлж эерэг нөлөө үзүүлэх ёстой хүчтэй хэрэглүүрийн нэг юм. Энэхүү сурган хүмүүжүүлэх харилцаанд нэг талаас багш, нөгөө талаас сурагчид оролцож, улмаар харилцаа бол хоёр субъект харилцан бие биедээ нөлөөлөх, мэдээлэл солилцох үйл явц юм.

- Ямар нөхцөл бүрдүүлбэл багш сурагчидтай харилцаа тогтоож чадах вэ? Энд хүн хүнээ хүртэж хүлээн авах анхны төсөөлөл чухал. Иймд хүн ямар нэг хүнтэй харилцахдаа бусдад таалагдах сэтгэгдэл төрүүлэх маш чухал юм.

- Говийн догшин хутагт Данзанравжаа “Учирсан бүхнийхээ нүүр царайг уяхан даруухан инээмсэглэн харж бай. Өнөр өтгөн, урт удаан наслыхын өлзий буян бүрдэх болно” хэмээн айлдсан байдаг нь багш хүнд хамгийн их хамаатай сургаал юм.

- Харилцаа нь: 
- Үгийн
- Үгийн бус

гэсэн хоёр янз байдгийн аль алиныг нь багш бүтээлчээр хэрэглэж чаддаг байх ёстой. Багш сурагчийн харилцаа амжилттай болох үндсэн нөхцөл бол:

- Багш хүүхэд бүрийг хувь хүнийх нь хувьд хүндлэх, түүний бүхий л эрхийг дээдлэх

- Хүүхдийн санаа бодлыг анхааралтай, дуустал нь сонсох, ойлгох зэрэг харилцааны техникийг багш эзэмших явдал юм.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УР ЧАДВАР ГЭЖ ЮУ ВЭ?

- Сургах чадвар

- Багшийн сургах чадвар нь нарийн нийлмэл ойлголт юм. Багшийн сургах чадварт дараах чадварууд багтана. Үүнд:
- Хичээл сургалт хүмүүжлийн ажлын зорилго, зорилтыг тодорхой ойлгомжтой тодорхойлох
- Суралцагтайгаа хамтран сургалтынхаа зорилго, зорилтыг ярилцаж нэгдсэн зорилгод хүрэх
- Сургалтын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх суралцагч төвтэй технологи боловсруулах
- Сургалтын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, танилцуулах
- Тухайн сургалтын талаар суралцагчдын амьдрал орчноос олж авсан мэдлэг туршлагыг судалж тодорхойлох, дүн шинжилгээ хийх
- Тухайн сургалтаар суралцагчид чухам ямар мэдлэг, туршлага зэргийг төлөвшүүлэхийг урьдчилан төсөөлөх, боловсруулах
- Суралцагчид тухайн хичээл сургалтаас юу хүсэн хүлээж буй, юу мэдэхийг хүсч буйг илрүүлэх
- Суралцагчийг сэдэлжүүлэх
- Суралцагчдад сонсох, бодох хангалттай цаг хугацаа өгөх
- Суралцагчдад ярих, унших, бичих зэрэг чадвар эзэмшүүлэх
- Суралцагчдын яриаг анхааралтай сонсох, тэдний бичсэн материалд шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- Суралцагчдын хийж чадах дасгал бодлого, даалгавар, тарааж өгөх материал, тест зэргийг боловсруулж бэлтгэх
- Суралцагчдад тавих ойлгомжтой, товч, тодорхой асуултыг боловсруулж бэлтгэх
- Тухайн сэдэвтэй холбоотой баримт, жишээг амьдрал практикаас олж бэлтгэх
- Суралцагчдад ухаалаг, зарчимч шаардлага тавих
- Суралцагчдыг урамшуулан дэмжих, итгэл өгч зоригжуулах
- Суралцагчдад зөвлөн туслах, чиглүүлэх
- Суралцагчдад санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгох
- Суралцагчдын мэдлэг чадварыг болитой үнэлж дүгнэх, алдааг нь өөрсдөөр нь засуулах
- Суралцагчидтай хамтран ажиллах
- Суралцагчдаар тодорхой асуудлаар эрэл хайгуул хийлгүүлэх
- Суралцагчдаар асуудал шийдвэрлүүлэх
- Суралцагчдаар “Бүтээлийн сан” бүтээлгэх, тэдний дунд бүтээлч ажил хийлгэх
- Суралцагчдаар сургалтын үр дүнд дүгнэлт хийлгэх, тэдний сэтгэл ханамжийг судлах гэх мэт.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭВ ДҮЙ

Сурган хүмүүжүүлэх ухааны зохиол бүтээлд эрдэмтэн судлаачид багшийн эв дүй, сурган хүмүүжүүлэх эв дүй гэсэн хагдахууныг өргөн хэрэглэдэг бөгөөд энэ ухагдахууны утга санааг олон янзаар ойлгох, тодорхойлох байдал ажиглагддаг.

- Сурган хүмүүжүүлэх эв дүй бол багшийн хүүхдэд үзүүлэх сурган хүмүүжүүлэх нөлөөллийн хэмжээ/тун/-г тухайн нөхцөл байдлаа харгалзан тохируулан оновчтой хэрэглэх өвөрмөц чадамж юм.
- Сурган хүмүүжүүлэх эв дүйн чухал бүрэлдэхүүн хэсэг бол багш маш богино хугацаанд аль болох хурдан оновчтой арга барилыг сонгон хэрэглэх явдал юм. Энэ нь тухайн багшийн мэдрэмж, туршлага, хувийн чанаруудаас ихээхэн хамаарна.
- Эрдэмтэн судлаач С.Нэргүй “Сурган хүмүүжүүлэх эв дүйгүй багш нэгбол захирах, айлгах замд, эсвэл хэт нөхөрсөг байдалд гарцаагүй ороод эцэстээ өөрийгөө хүүхдүүдээс хөндийрүүлнэ” гэж тэмдэглэсэн байдаг⁸.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭВ ДҮЙ

- Багш хүн хүүхдийг амжилттай сургахын тулд мэдлэгийг бүтээх, түүнийг сурагчийн чадвар, дадал, итгэл үнэмшил болгох, хүүхэд бие дааж сэтгэн бодох, бүтээлчээр ажиллах зэрэг арга барил хэр зэрэг эзэмшсэнийг нь хянаж шалгах, бодит үнэлгээ өгөх зэрэг олон төрлийн үйл ажиллагаа хийж гүйцэтгэнэ. Эдгээр үйл ажиллагаа тус бүрт багшийн сурган хүмүүжүүлэх эв дүй зайлшгүй хэрэгтэй болно. Эв дүй нь эцсийн эцэст сурагчдын мэдлэг, арга барил, чадвар дадал, бие хүний эрхэм сайн чанар зэргийг бат бэх эзэмшиж авахад нь чиглэж тус дэм болох үүрэгтэй.
- Багш нар тодорхой насны хүүхэдтэй харилцахдаа түүний насны болон хувийн онцлог, түүнд ямар чанар төлөвшүүлэхийн тулд ямар нөлөөлөл үзүүлэх ба үүний тулд ямар арга илүү тохирох зэргийг харгалзан тодорхой арга барил, хэрэглүүр, “зай” зэргийг сонгож хэрэглэнэ. Жишээлбэл, зарим хүүхдүүд багш, сурагчид “ойр дотно харилцах” хэрэгтэй гэж үздэг. Энэ бол тийм ч энгийн зүйл биш юм.
- Багш, сурагчид харилцааны зай, зах хязгаарыг алдаж хэт ойртож дотносох/зай байхгүй болох/, илэн далангүй болох юм бол багш хүүхдэд сурган хүмүүжүүлэх нөлөөлөл үзүүлж чадахгүйд хүрч болох талтай. Ийм байдлыг зуун хувь үгүйсгэж болохгүй ба ийм ойр, илэн далангүй байдал маш цөөн, онцгой тохиолдолд байж болох ба үргэлж байж хэзээ ч болохгүй.
- Багш, сурагчид харилцааны зохистой зайгаа алдаж хэт хол хөндий болбол багш хүүхдэд мурган хүмүүжүүлэх нөлөөлөл үзүүлж чадахгүйд хүрнэ. Иймээс багш хүүхдэд сурган хүмүүжүүлэх эерэг нөлөөлөл үзүүлэхийн тулд харилцааны зохих “зай”-гаа олж тохируулах шаардлагатай. Энэхүү “зай” үргэлж нэг хэвээр байхгүй нь мэдээж, нөхцөл байдлаас шалтгаалж ихэсч, багасч байх ба лээрх хоёр туйл уруу хэзээ ч хүрч болохгүй.
- Өөрөөр хэлбэл, багш харилцааны эв дүйтэй байна гэдэг бол сурагчтайгаа харилцах зайг хэт ойр эсвэл хэт хол болгохгүй түүнд нөлөөлж болох тийм хэмжээнд байлгана гэсэн үг юм.
- Багш харилцааны эв дүйтэй байна гэдэг нь мөн багшийн хүүхдэд үзүүлэх сурган хүмүүжүүлэх нөлөөлөл эртдэж эсвэл оройтож болохгүй яг цаг хугацаа, орон зайгаа олсон байна гэсэн үг юм.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭВ ДҮЙ

Зарим багш нар сурган хүмүүжүүлэх эв дүйд багшийн зүгээс хүүхдийн эвийг олох, түүнд “*таарах түлхүүр*”-ийг олох, түүний сайн талд тулгуурлах, өөдрөг хандах гэх мэт зүйл багтана гэж үздэг. Эв дүйтэй багш бол яах аргагүй олон түлхүүртэй багш бөгөөд тухайн нөхцөлд “*тодорхой хүүхдэд тохирох л түлхүүрийг сонгон*” хэрэглэж чаддаг.

- ***Багш сурган хүмүүжүүлэх эв дүй эзэмших үндсэн нөхцөл бол:***
- Хүүхдийн насны, хувийн онцлогийг сайтар судалж танин мэдэх, эдгээрийг харгалзаж, ялгавартай ажиллаж сурах
- Хүүхдэд нөлөөлөх шинэ арга барилыг үргэлж хайж байх
- Ажигч гярхай байх
- Хурдан, уян хатан, гүнзгий сэтгэх
- Аливаад хүлээцтэй хандах
- Хүүхдийг ямар ч нөхцөлд эвгүй байдалд оруулахгүй байхыг хичээх
- Сурган хүмүүжүүлэх техникийг эзэмших гэх мэт
- Сурагч амжилттай сурч хөгжих нь юуны түрүүнд багшийн эв дүйтэй хамгийн их холбоотой юм.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭВ ДҮЙН ШИНЖҮҮД

- Сургалт хүмүүжлийн ажил эцсийн эцэст багш суралцагч хоёрын харилцаа, хамтын ажиллагааны арга барил, эвслээс шууд хамаарна. Өөрөөр хэлбэл эв дүй дутсанаас сурч хүмүүжих ажлын үр дүн, өгөөжид сөргөөр нөлөөлдөг билээ. Учир иймд багш хүн сурган хүмүүжүүлэх эв дүйн чухал шинжүүдийг эзэмшсэн байх зайлшгүй шаардлагатай. Үүнд:

- **Ажилч гярхай шинж**

Энэ чанар нь багш хүний чухал шинж бөгөөд хүүхдийнхээ дотоод мөн чанарыг ойлгож, тэдний дотоод ертөнцөд гүнзгий нэвтэрч, санаа бодлыг нь соргоогоор мэдэрч чаддаг байх ёстой. Энэ чанар нь төрөлхийн зүйл биш, сэтгэхүйн хөгжил дэвшилтэй холбоотой байнга сайжирч хөгжиж байх ёстой чанар юм.

- **Анхаарах чадвар**

Багш хүн шинэ зүйл, шинэ материалыг тайлбарлан таниулах төдийгүй, бас суралцагчдынхаа үг яриа, санаа бодлыг сонсч чаддаг байх нь нэн чухал юм. Жишээ нь: Нэг хүүхдийн балны бэх дуусч, арынхаа хүүгээс гуйсан боловч өгсөнгүй. Багшид мэдэгдэх гэж гараа өргөөд ч түүнийг анхаарсангүй. Эцэст нь багшийн ширээн дээрээс бэх авах гэж босохдоо хажуугаараа өнгөрсөн охиныг түлхэн зөрж ширээгээ түлхэн суухад багш анхаарч ангиас хөөн гаргав. Эндээс харахад хэрэв багш эрт анхаарсан бол ийм зүйл болохгүй, бусдад ч түвэг учрахгүй байв. Анхаарал үнэхээр ач холбогдолтой гэдгийг өгүүлж байна.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭВ ДҮЙН ШИНЖҮҮД

○ Шавьдаа итгэх итгэл

Шавь нарынхаа авьяас чадвар, ололттой сайн талыг олж харж чаддаг, тэдэнд итгэж чаддаг байхаас сурган хүмүүжүүлэх эв дүй үлэмж хамаарна. Иймд багш хүн шавь нарынхаа авьяас чадвар, мэдлэг оюун, хүч боломжийг үнэлж тэдэнд итгэл найдвар хүлээлгэж чаддаг байх шаардлагатай.

Нэгэн ой тогтоолт муутай хүү байжээ. Багш нь чи бахь байдгаараа байвал чи анги улирна, юу ч сурахгүй гэжээ. Тухайн хүү ч сургуульдаа ирэхээ больжээ. Харин дараагийн ангийн багш нь хүүд итгэл өгч “Чи чадна” гэснээр хүү амжилттай сурч эхэлжээ. Энэ бол шавьдаа итгэл өгч урам зоригийг нь хөгжүүлж чадвал юунд хүрдгийг харуулж байгаа хэрэг.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ТЕХНИК

- Сурган хүмүүжүүлэх эв дүй нь сургалтын практикт сурган хүмүүжүүлэх техникээр дамжин хэрэгждэг.

Судлаач Л.И.Рувинский сурган хүмүүжүүлэх техник хэмээх ойлголтыг *“багшийн өөр хүн болж хувирах, дуу хоолой, нүүрний хувирал болон биеийн хөдөлгөөн зэргээ хооронд нь зохицуулан өөрчлөх бүтээлч үйлүүд”* гэж үзсэн байдаг.

Мөн судлаач Л.А.Байкова *“Сурган хүмүүжүүлэх техник нь багшийн сурган хүмүүжүүлэх ажлын дотоод мөн чанар болон түүний гадаад илрэл хоорондоо нийцэж байх явдал”* гэж үзсэн байна.⁵

Л.И.Рувинский, Л.А.Байкова нар сурган хүмүүжүүлэх техникийг

- -Багшийн өөрийгөө удирдах техник
- -Багшийн бусад хүмүүст нөлөөлөх техник гэж хоёр хуваан авч үзсэн байна
- *Багшийн өөрийгөө удирдах техникт:*

Дуу хоолой, нүүрний хувирал, амьсгал, хэл яриа, хөдөлгөөн, хүртэхүй, сэтгэлийн хөдөлгөөн, хувцаслалтын техник багтдаг.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ТЕХНИК

- **Багш дуу хоолойгоо эзэмдэх техник нь** багш гаргаж буй дуу авиагаа ойр, дунд, холын зайд хүргэх, чухам ямар зайд хүргэхээ тооцоолох, тохируулах арга барил. Багшийн дуу хоолой үргэлж нэг хэвээр байж болохгүй ба ярьж буй орон зайнаас шалтгаалж өөрчлөгдөж байх учиртай.
- Тодорхой нөхцөл, хэрэгцээ, зорилгоос шалтгаалж багшийн дуу зарим үед өндөр, заримдаа дунд зэрэг, мөн нам болж байх ба дууны өнгө нь аль болох зөөлөн мөртлөө итгэлтэй байх хэрэгтэй.
- Энд багш нарын гаргадаг түгээмэл алдаа бол багш үргэлж чанга ярих, нэг өнгөөр удаан ярих, эсвэл сурагчдад дуулдахгүй намдуугаар ярих нь байдаг.
- **Нүүрний хувирлын техник нь** багш элгсэг найрсаг, төлөв түвшин, тайван, өөртөө итгэлтэй, хүүхдэд өөдрөг ханддаг, хүүхдийг байгаагаар нь ч хүлээн авч ойлгоход, туслахад бэлэн байгаа байдлыг илэрхийлэх арга барил. Ингэхдээ багш сэтгэл санааны таагүй байдлаа нуун далдалж чаддаг байх нь зүйтэй.
- Нүүрний хувирлын техникт Багшийн харц зөөлөн, баярласан байдлыг илэрхийлэхийн хамт итгэлтэй, нөгөө хүний нүд, нүүр үрүү чиглэсэн байна. Ингэхдээ багшийн нүдний хөдөлгөөн тогтвортой, хэт их хөдөлгөөнтэй бус байх нь зүйтэй.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ТЕХНИК

- Хэл ярианы техник нь багш үгийг цэвэрхэн тод хэлэх, хэт чанга бус, хэт намуун бус ярих буюу ярианы өндөр нам нь ьухайн нөхцөлд тохирон өөрчлөгдөж байх чухал. Хэрвээ багш үргэлж чанга яривал хүүхдүүд болон багш өөрөө их ядрахын зэрэгцээ хүүхдүүд багшийг сонсохгүй анхаарал нь сарниж өөр зүйл хийх жишээтэй. Иймээс ямар тохиолдолд өндөр, дунд, нам ярихаа тохируулж сурах их чухал техник юм. Мөн багшийн яриа хэт хурдан, эсвэл удаан бус тухайн насны хүүхдийн сонсох чадварыг харгалзан хурдаа тохируулдаг байх шаардлагатай. Багш хүүхдэд ойлгомжтой, товч, тодорхой ярьж хэвших нь энэ техникийн нэг чухал хэсэг бөгөөд багш хүн ярианы техникийг бүрэн эзэмшсэн/ мастерство/ байх ёстой.
- Хөдөлгөөний техник нь багш ангид яаж алхаж гишгэх, яаж суух, гараа ямар байдалтай байлгах, толгойгоо яаж хөдөлгөх гэх мэт зэргийг эвсэлтэй, зөөлөн, хөнгөн хийх урлагийг хэлнэ. Тухайлбал, багш ангид хүнд алхах, гараа их хөдөлгөх, толгойгоо янз бүр болгон хөдөлгөх нь сурагчдын анхаарлыг сарниулах муу нөлөөтэй байдаг.
- Сэтгэлийн хөдөлгөөнөө эзэмдэх техник нь багш сэтгэлийнхээ эерэг болон сөрөг хөдөлгөөнийг хянах ба сэтгэл санаагаа зөв илэрхийлэх арга барил юм. Мөн багш уур уцаараа эзэмдэх, дарах энгийн дасгал хийх арга барилтай байх шаардлагатай. Тухайлбал, уур хүрсэн тохиолдолд “Би тайван байна... Би тайван байна...” гэж өөрөө өөртөө арван удаа хэлэх жишээтэй. Багш зарим үед их ядрах тохиолдол гардаг. Ийм үед зуны амралтын сайхан өдрүүд, амьдралдаа тохиолдож байсан ямар нэгэн сайхан дурсамж зэргийг эргэн бодоход ядаргаа амархан тайлагдана.



СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ТЕХНИК

- Хувцаслалтын техник Багш хүн өөрийн зүс царайдаа тохируулан зохистой хувцаслах арга барилыг хэлнэ. Багш олон өнгийн, эрээн, хурц өнгөтэй, хэт этгээд загварын хувцас өмсч хүүхдийн анхаарлыг сарниулах нь зохисгүй. Багшийн хувцас нь нэг, хоёроос дээшгүй өнгөтэй байх ба ямар ч нөхцөлд сонгодог өнгөний хослол бол хар, цагаан юм.
- Эмэгтэй багш нарын хувьд ямар ээмэг, бөгж зүүхээ ч бас л анхаарч бодох л зүйлийн нэг юм.
- Хүртэхүйн техник нь багш анхаарал, төсөөлөн бодохуй, ургуулан бодохуй, ой тогтоолт зэргээ байнга хөгжүүлэх арга барил юм. Багш хүн байнга анхааралтай байх ёстой нь энэ мэргэжлийн онцлог бөгөөд ялигүй зүйлийг ч орхилгүй ажиглаж байх хэрэгтэй болдог.
- Багш хичээлийн явцад болон бусад үед хийсвэрлэн бодох чадвараа байнга ашиглаж байж сургалтаа амжилттай зохион байгуулна. Хувийн онцлогтой олон янзын хүүхэдтэй ажиллахдаа тэдний сэтгэл санааг үргэлж мэдэрч ажиллах явдал бол гарцаагүй чухал зүйл бөгөөд түүнгүйгээр багшийн ажил хэзээ ч амжилттай болж чадахгүй.



Анхаарал тавьсан
Танд баярлалаа

